



МИК ХОЛДИНГ ХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 21 оны 11 сарын 03 өдөр

№ 21/49

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг түр томилох тухай

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын 20 дугаартай дүгнэлт, “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 35 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах ердийн гишүүн Сайнбаярын Батчимэгийг 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөр Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. Энэ тогтоолын 1-т заасантай холбогдуулан чөлөөлөгдсөн ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдээр “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн Ерөнхийлөгч Эрдэнэбилэгийн Тулгыг 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн С.Батчимэгийн хэрэгжээгүй үлдсэн бүрэн эрхийн хугацаанд түр томилсугай.
3. Э.Тулга нь энэ тогтоолын 2-т заасан бүрэн эрхийн хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлж, С.Батчимэгийн гишүүнчлэл бүхий Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хорооны бүрэлдэхүүнд орж ажиллахыг дурдсугай.
4. Э.Тулгатай “Нууц үл задруулах гэрээ” байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (М.Мөнхбаатар)-д даалгасугай.
5. Э.Тулгын бүрэн эрхийн хугацаа хэрэгжиж эхэлсэн өдрөөс эхлэн холбогдох журмын дагуу батлагдсан төсвийн хүрээнд цалин олгохыг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.
6. Энэ тогтоолд зааснаар Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх холбогдох хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн талаар зохих хууль тогтоомжид заасан журмын дагуу хувьцаа эзэмшигч болон олон нийтэд мэдээлэл хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба (Г.Саруул)-нд даалгасугай.
7. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо (Ч.Хашчулуун)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

М.МӨНХБААТАР



★★★★